

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2025/095/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Арвайхээр хот

2025 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер: П.Хорлоосүрэн

Утас: 70323833 Цахим хаяг: KhorloosurenP@audit.gov.com

Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг

Утас: 70323108 Цахим хаяг:

Erdenetsetsegb@audit.gov.mn

Аудитор: Э.Энхбаяр

Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.11.09 № 01
танай _____-ны № _____-т

ШҮҮХИЙН ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭЛИЙН ГАЗРЫН
ДАРГА Ч.ЦЭНГЭЛБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг Өвөрхангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд улсын төсвөөс 1,184.2 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар 44.5 сая төгрөгийн санхүүжилт авч үндсэн данснаас цалин, нийгмийн даатгалын шимтгэл, бараа үйлчилгээний зардлыг, нэмэлт санхүүжилтийн данснаас шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нарын тусгай хэрэгсэл, хоригдол, ялтангуудад сургалт зохион байгуулахад зарцуулж 0.3 сая төгрөгийг төвлөрүүлжээ. Өвөрхангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2024 онд иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар 1384 гүйцэтгэх баримт бичгийн 19042.8 сая төгрөгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас 584 гүйцэтгэх баримт бичгийн 7018.5 сая төгрөгийг биелүүлж, 804 гүйцэтгэх баримт бичгийн 12024.3 сая төгрөгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа шийдвэрлэгдээгүй байна. Харин хөрөнгө болон торгох ялын 628 гүйцэтгэх баримт бичигт хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албадлагын арга хэмжээний ял эдлүүлж ажилласан байна. Үүнээс торгох ялын 201 гүйцэтгэх баримт бичгийн 303.0 сая төгрөгт эрүүгийн шийтгэх үйл ажиллагаа явуулж 167 гүйцэтгэх баримт бичгийн 238.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд үүнээс орон нутгийн төрийн сангийн 100101900987 тоот дансанд 87.7 сая төгрөг, төв төрийн сангийн 100900012060 тоот дансанд 131.5 сая төгрөг, орон нутгийн 100100000988 тоот дансанд 19.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

015030018

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант үеийн санхүүгийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байна. Бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

		Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31.
Санхүүгийн байдлын тайлан				
	Эргэлтийн хөрөнгийн дүн		57,064.4	117,458.9
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		1,269,350.8	1,419,543.7
	Нийт хөрөнгийн дүн		1,326,415.2	1,537,002.6
	Нийт өр төлбөрийн дүн		-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн		1,326,415.2	1,537,002.6
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн		1,326,415.2	1,537,002.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан				
	Үйл ажиллагааны орлогын дүн		1,057,542.9	1,469,139.4
	Үйл ажиллагааны зардлын дүн		1,079,378.2	1,258,288.6
	Үйл ажиллагааны үр дүн		(21,835.3)	210,850.8
	Үйл ажиллагааны бус үр дүн		(1,211.3)	(263.3)
	Үйл ажиллагааны нийт үр дүн		(23,046.5)	210,587.4
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан				
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		1,349,461.7	1,326,415.2
	Тайлант оны үр дүн		(23,046.5)	210,587.4
	Эцсийн үлдэгдэл		1,326,415.2	1,537,002.6
Мөнгөн гүйлгээний тайлан				
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн		1,015,580.1	1,228,806.2
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн		1,015,580.1	1,207,818.2
	Үйл ажиллагааны ЦМГ		-	20,988.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		-	(20,988.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан				
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		-	1,228,412.9
	Урсгал зардал		-	1,228,412.9
	Хөрөнгийн зардал		-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		-	1,184,568.5
	Улсын төсвөөс санхүүжих		-	1,184,468.5
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган
төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		

1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6217143681
ИЮА0059 9044094